



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДАРХАН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2025 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2026/З/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор С.Санжаажав

Утас: 70373089 Цахим хаяг: Sanjaajavs@audit.gov.mn



Дархан-Уул аймаг

2026 он



## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

“ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН  
СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ М.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

2026.03.11 № 172  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд өөрийн хөрөнгөөр 1,498,744.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга, биет бус хөрөнгө худалдан авч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 430.9 сая.кВт.ц ЦЭХ, 749.7 мян.Гкал ДЭХ боловсруулж, 370.0 сая.кВт.ц ЦЭХ, 726.8 мян.Гкал ДЭХ түгээсэн нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс ЦЭХ 0.7 хувиар буурч, ДЭХ 7.3 хувиар өсөж, борлуулалтын орлого 12,387,742.1 мянган төгрөг

4526050287

буюу 16.5 хувиар нэмэгдэж, 18,016,115.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 86 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 96.4 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	327,079,804.91	237,214,271.21
1.1.2	Дансны авлага	3,928,276,619.17	9,040,663,621.49
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	374,064,687.33	886,393,712.41
1.1.4	Бусад авлага	954,124.61	507,076.43
1.1.6	Бараа материал	6,507,375,712.96	6,433,870,700.54
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	832,056,453.08	903,031,507.94
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>11,969,807,402.06</b>	<b>17,501,680,890.02</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	130,895,986,527.16	126,757,956,042.47
1.2.2	Биет бус хөрөнгө	25,036,455,896.67	24,922,327,629.43
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>155,932,442,423.83</b>	<b>151,680,283,671.90</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>167,902,249,825.89</b>	<b>169,181,964,561.92</b>
2.1.1.1	Дансны өглөг	3,825,314,582.57	11,807,973,940.17
2.1.1.2	Цалингийн өглөг	-	690,412,056.00
2.1.1.3	Татварын өр	-	2,540,784,719.76
2.1.1.5	Богино хугацаат зээл	1,595,971,189.51	1,999,999,998.95
2.1.1.6	Хүүний өглөг	10,096,164,604.86	11,398,365,756.80
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,991,999,508.00	273,005,590.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	85,553.47	-
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>18,509,535,438.41</b>	<b>28,710,542,061.68</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	63,753,302,659.67	72,965,271,651.21
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>63,753,302,659.67</b>	<b>72,965,271,651.21</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>82,262,838,098.08</b>	<b>101,675,813,712.89</b>
2.3.1	Төрийн өмч	9,992,637,872.43	9,992,637,872.43
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	74,507,202,298.57	74,390,057,644.81
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	23,699,196,000.00	23,699,196,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(22,559,624,443.19)	(40,575,740,668.21)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>85,639,411,727.81</b>	<b>67,506,150,849.03</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>167,902,249,825.89</b>	<b>169,181,964,561.92</b>



## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>75,144,338,725.03</b>	<b>87,532,080,797.46</b>
2	Борлуулалтын өртөг	77,584,385,126.66	88,707,525,552.90
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>(2,440,046,401.63)</b>	<b>(1,175,444,755.44)</b>
5	Хүүгийн орлого	1,649,278.51	3,070,127.31
8	Бусад орлого	7,706,118,404.87	3,154,460,776.95
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,211,177,942.56	1,583,539,924.09
11	Санхүүгийн зардал	272,067,121.87	142,800,527.80
12	Бусад зардал	4,579,108,945.99	5,947,951,258.56
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	4,643,178,776.88	(12,440,748,304.42)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	90,955,748.93	117,144,653.76
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>3,939,501,797.14</b>	<b>(18,015,809,212.29)</b>
19	Орлогын татварын зардал	164,927.87	307,012.73
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>3,939,336,869.27</b>	<b>(18,016,116,225.02)</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>3,939,336,869.27</b>	<b>(18,016,116,225.02)</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>3,939,336,869.27</b>	<b>(18,016,116,225.02)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>		



### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,040,100,005.47	71,884,437,391.18	23,699,196,000.00	(26,498,961,312.46)	79,124,772,084.19
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	10,040,100,005.47	71,884,437,391.18	23,699,196,000.00	(26,498,961,312.46)	79,124,772,084.19
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	3,939,336,869.27	3,939,336,869.27
6	Өмчид гаргасан өөрчлөлт	(47,462,133.04)	2,718,692,751.46	-	-	2,671,230,618.42
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(95,927,844.07)	-	-	(95,927,844.07)
9	<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>9,992,637,872.43</b>	<b>74,507,202,298.57</b>	<b>23,699,196,000.00</b>	<b>(22,559,624,443.19)</b>	<b>85,639,411,727.81</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	9,992,637,872.43	74,507,202,298.57	23,699,196,000.00	(22,559,624,443.19)	85,639,411,727.81
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(18,016,116,225.02)	(18,016,116,225.02)
14	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(117,144,653.76)	-	-	(117,144,653.76)
17	<b>2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>9,992,637,872.43</b>	<b>74,390,057,644.81</b>	<b>23,699,196,000.00</b>	<b>(40,575,740,668.21)</b>	<b>67,506,150,849.03</b>




## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>79,353,432,128.77</b>	<b>76,800,954,210.11</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	71,189,170,069.51	76,532,232,703.52
1.1.6	Бусад мөнгөн орлого	8,164,262,059.26	268,721,506.59
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>77,772,127,621.21</b>	<b>75,905,568,303.32</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	16,512,272,604.83	17,555,416,407.51
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,206,580,000.00	6,035,849,407.39
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	18,237,038,612.06	15,933,499,743.46
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	30,336,129,600.32	31,125,050,809.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	963,281,031.00	452,569,652.63
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	6,382,767,816.41	4,664,514,242.22
1.2.9	Бусад мөнгөн зарлага	134,057,956.59	138,668,041.11
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,581,304,507.56</b>	<b>895,385,906.79</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,649,278.51	3,070,127.31
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,649,278.51	3,070,127.31
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,663,775,965.39	1,358,547,695.34
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,663,775,965.39	1,358,547,695.34
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,662,126,686.88)</b>	<b>(1,355,477,568.03)</b>
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,804,293,630.24	8,201,855,669.17
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	9,804,115,973.00	8,198,789,391.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	177,657.24	3,066,278.17
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,729,322,239.95	7,831,629,541.63
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	9,728,011,533.96	7,831,629,525.46
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	1,310,705.99	16.17
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>74,971,390.29</b>	<b>370,226,127.54</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(5,850,789.03)</b>	<b>(89,865,533.70)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>332,930,593.94</b>	<b>327,079,804.91</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>327,079,804.91</b>	<b>237,214,271.21</b>



## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Хэмжих нэгж	2025 он		зөрүү	Хувь
				Батлагдсан төлөвлөгөө	гүйцэтгэл		
	2		3	4	5		
1	Боловсруулах	ЦЭХ	квтц	428,595.0	430,981.7	2,386.7	100.6
		ДЭХ	гкал	725,577.0	749,667.6	24,090.6	103.3
	ДХЦЭХ	хувиар	%	14.2	14.0	(0.2)	98.6
		биетээр	квтц	60,679.0	60,174.6	(504.4)	99.2
	Түгээх	ЦЭХ	квтц	367,023.5	370,043.0	3,019.5	100.8
		ДЭХ	гкал	702,577.0	726,803.6	24,226.6	103.4
2	Нийт орлого		Мян.төг	96,674,502.2	94,753,764.1	(1,920,738.1)	98.0
	Үүнээс :Борлуулалтын орлого		Мян.төг	87,220,156.9	87,532,080.8	311,923.9	100.4
		Татаас орлого	Мян.төг	-	-	-	-
	үйл ажиллагааны бус орлого		Мян.төг	9,454,345.3	7,221,683.3	(2,232,662.0)	76.4
3	Нийт зардал		Мян.төг	103,738,640.0	112,769,819.0	9,031,179.0	108.7
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал		Мян.төг	94,180,440.3	95,207,345.8	1,026,905.5	101.1
		Түлш	Мян.төг	43,203,004.0	42,509,117.6	(693,886.4)	98.4
		Элэгдэл	Мян.төг	13,536,100.0	14,465,871.3	929,771.3	106.9
		Бусад тогтмол	Мян.төг	37,441,336.3	38,232,357.0	791,020.6	102.1
	Үйл ажиллагааны бус зардал		Мян.төг	9,558,207.9	17,562,534.5	8,004,326.6	183.7
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		Мян.төг	(7,064,145.4)	(18,016,116.2)	(10,951,970.8)	255.0
5	Татварын дараах ашиг /алдагдал/		Мян.төг	(7,064,145.4)	(18,016,116.2)	(10,951,970.8)	255.0
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		Мян.төг	1.1	1.1	0.0	100.7
7	Нийт авлага		Мян.төг	1,971,600.0	9,927,564.4	7,955,964.4	503.5
	Үүнээс:	ЭХ-ний	Мян.төг	1,971,600.0	9,040,663.6	7,069,063.6	458.5
		Бусад	Мян.төг	-	886,900.8	886,900.8	-
8	Нийт өглөг		Мян.төг	90,680,000.0	101,675,813.7	10,995,813.7	112.1
	Үүнээс:	Богино хугацаат өр	Мян.төг	16,180,000.0	28,710,542.1	12,530,542.1	177.4
		Урт хугацаат өр	Мян.төг	74,500,000.0	72,965,271.7	(1,534,728.3)	97.9
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	471.0	470.0	(1.0)	99.8
10	Нийт цалингийн сан		Мян.төг	22,275,300.1	22,786,722.9	511,422.8	102.3
11	Жишмэл түлшний зарцуулалт	ЦЭХ	гр/кВтц	431.1	426.2	(4.9)	98.9
		ДЭХ	кг/Гкал	190.2	183.1	(7.1)	96.3
12	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		Мян.төг	11,899,390.0	11,135,603.6	(763,786.4)	93.6
	Их засвар		Мян.төг	7,122,303.8	7,438,789.8	316,486.0	104.4
	ТЗБАХ		Мян.төг	3,292,000.0	2,599,885.7	(692,114.3)	79.0
	хөрөнгө оруулалт		Мян.төг	1,485,117.0	1,096,928.0	(388,189.0)	73.9
	Санхүүжих	2025 он	Мян.төг	9,085,990.0	9,573,550.0	487,560.0	105.4
		2026 он	Мян.төг	2,813,400.0	2,325,836.0	(487,564.0)	82.7



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 76,550.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил<sup>1</sup> илрүүлж 1,056.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 75,494.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

- Тайлант онд тус станцын захиргаа удирдлагын хэлтсийн хуульч Д.Сэргэлэнд ТУЗ-ын нарийн бичгийн даргын үүрэгт ажлыг сайн гүйцэтгэж компанийн засаглалыг сайжруулах ажилд бодитой хувь нэмэр оруулсан гэсэн үндэслэлээр 1,056.0 мянган төгрөгөөр шагнаж, үр ашиггүй зардал гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно;”, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.1-д “хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;”, 84.4.2-д “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;”, Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3.19-д “Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тухайн компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, журам, заавар гаргах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Зөвлөмж

#### 5.2.1. Зардлын данстай холбоотой холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Тайлант онд ном хэвлүүлэх, видео контент хийх зэрэгт нийт 75,494.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.14-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж, үр ашиггүй зардал гаргахгүй байх.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд тус станцын захиргаа удирдлагын хэлтсийн хуульч Д.Сэргэлэнд ТУЗ-ын нарийн бичгийн даргын үүрэгт ажлыг сайн гүйцэтгэж компанийн засаглалыг сайжруулах ажилд бодитой хувь нэмэр оруулсан гэсэн үндэслэлээр 1,056.0 мянган төгрөгөөр шагнаж, үр ашиггүй зардал гаргасан байна	1	1,056.0	1	1,056.0								
Тайлант онд ном хэвлүүлэх, видео контент хийх зэрэгт нийт 75,494.0 мянган төгрөг зарцуулсан байна	1	75,494.0						1	75,494.0			
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>76,550.0</b>	<b>1</b>	<b>1,056.0</b>			<b>1</b>	<b>75,494.0</b>				